

**“ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙН ЗӨВЛӨХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ОЛОН УЛСЫН НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА**

*/ урьдчилсан сонгон шалгаруулалт/*

**Төслийн дугаар:** BMZ201465129/BMZ201665009

**Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК

**Тендер зарлагдсан огноо:** 2020.03.20 **Дуусах огноо:** 2020.04.20

Монгол улсын Засгийн газар болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагаа”-ны хүрээнд ХБНГУ-аас эрчим хүчний салбарт олгох 20 сая 450 мянган еврогийн хөнгөлттэй зээлийн хөрөнгө оруулалтыг Герман улсын Сэргээн босголт, зээлийн банкаар (KfW) дамжуулан “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК дээр хэрэгжих “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-д олгохоор хоёр орны “Санхүүгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”-ийн баримт бичгүүдэд тусгаж талууд гарын үсэг зурж баталгаажуулсан.

Төслийн арга хэмжээний хүрээнд “ЦДҮС” ТӨХК-ийн 30 гаруй дэд станцад техник, технологийн хувьд хоцрогдсон, ашиглалтын хугацаа хэтэрсэн, хуучирч муудсан тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх ажлуудыг хийж, төвийн бүсийн эрчим хүчний системийн тасралтгүй найдвартай ажиллагааг сайжруулах юм.

**Зөвлөх үйлчилгээ:** Урьдчилсан шалгаруулалтын тухай энэхүү урилга нь Техникийн туслалцааны (ТТ) хүрээнд үзүүлэх үйлчилгээнд хамаарна. Зөвлөх нь энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд “ЦДҮС” ТӨХК-тай нягт хамтран ажиллана.

Зөвлөх нь дараах чиг үүргийн хүрээнд Техникийн туслалцаа үзүүлэх бөгөөд үүрэг нь зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй:

- Төслийн хэрэгжилтийн хүрээнд шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэхэд “ЦДҮС” ТӨХК-д дэмжлэг үзүүлнэ. Үүнд: шинэчлэлийн ажлын зураг төсөл, загвар батлах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг бэлтгэх, ирүүлсэн тендерийн материалуудыг үнэлэх гэх мэт
- Тоног төхөөрөмж ханган нийлүүлэх болон угсрах, засах, суурьлуулалтын гэрээт ажлууд нь шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зэрэг төслийн хэрэгжилтийн явцад мониторинг хийх, хяналт тавих
- Тайлан боловсруулах, түүнчлэн төслийн хэрэгжилтэнд ерөнхий дэмжлэг үзүүлэх...

Сонирхсон этгээд нь доорх холбоосоор орж, шаардлагатай нэмэлт мэдээлэл авна уу.

Англи хэлээр:

<https://www.gtai.de/gtai-en/trade/tenders/mongolia/consulting-services-for-project-implementation-energy-efficiency-measures-for-power-transmission-and-distribution-network-230630>

Герман хэлээр:

<https://www.gtai.de/gtai-de/trade/ausschreibungen/mongolei/consulting-projektimplementierung-energieeffizienzmassnahmen-231116>

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК  
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ  
batzorig@transco.mn